




НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
НАЛАЙХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

НАЛАЙХ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2025 ОН	3
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	4-5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	6
 ЭРҮҮЛ МЭНД	7-8
 СОЁЛ УРЛАГ	9
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	9
 ГЭМТ ХЭРЭГ	9-10
 ТӨСӨВ	11
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	11
 АЖ ҮЙЛДВЭР	12-13
 ХАРИЛЦАА ХОЛБОО	13
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	13- 14
 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ	15



ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТ 1. ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Суурин хүн ам, жилийн эцэст тоо	38 690	38 929	39 579	40 674	-
Шинээр төрсөн хүүхэд тоо	916	858	790	671	666
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн тоо	12 290	4 802	417	293	316
Бүртгэсэн гэмт хэрэг тоо	279	329	597	315	314
Орон нутгийн төсвийн орлого сая төгрөг	25 589.6	20 161.7	12 715.3	27 992.4	34 539.0
Орон нутгийн төсвийн зарлага сая төгрөг	26 080.4	19 143.6	14 403.4	30 982.7	34 137.0

Эх үүсвэр: Налайх дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2025 оны эхний 12 сард төрсөн 686 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 264 хүнийг бүртгэлээс хасаж, 126 хосын гэрлэлт, 54 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 (1.4%)-иар, нас баралт 33 (11.1%)-иар тус тус буурсан байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 53.9 хувь нь хүү, 46.1 хувь нь охин байна. Нийт нас баралтын 59.5 хувь нь эрэгтэй, 40.5 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

ХҮСНЭГТ 2. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТЫН БҮРТГЭЛ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Төрсөн хүүхэд, бүгд	904	783	790	696	686
Үүнээс: Эрэгтэй	492	391	400	361	370
Эмэгтэй	412	392	390	335	316
Нас баралт, бүгд	290	257	275	297	264
Үүнээс: Эрэгтэй	156	163	159	193	157
Эмэгтэй	134	94	116	104	107


ЗУРАГ 1. ХҮН АМЫН ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ



ХҮСНЭГТ 3. ГЭРЛЭЛТЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХОС, насны бүлгээр, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2023		2024		2025*	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Нийт	218	218	171	171	126	126
18-19	1	5	2	6	3	5
20-24	41	46	29	41	26	31
25-29	70	66	56	46	30	38
30-34	42	42	34	31	20	16
35-39	34	31	13	13	22	15
40-44	14	11	10	8	11	12
45-49	5	11	10	10	6	4
50 +	11	6	17	16	8	5

ЗУРАГ 2. ГЭРЛЭЛТЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХОС, насны бүлгээр




2025 оны эхний 12 сард гэрлэлтээ баталгаажуулсан 126 хос байгааг өмнөх оны мөн үетэй 45 (26.3%)-иар буурсан байна.

ХҮСНЭГТ 4. ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТ, жил бүрийн эхний 12 сар

Үзүүлэлт		2021	2022	2023	2024	2025*
Гэр бүл цуцлалт, бүгд		38	63	65	60	54
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	-	3	4	7	2
	1-3	5	21	6	5	1
	4-6	5	8	9	10	11
	7-9	6	6	11	11	10
	10-14	14	9	16	10	11
	15-19	2	6	9	6	14
	20 ба түүнээс дээш	6	10	10	11	5

ЗУРАГ 3. ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТ



2025 оны эхний 12 сард нийт 54 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Дүүргийн хэмжээнд гэр бүл цуцлалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 (10.0%)-иар буурсан байна. Дүүрэгт 2025 оны эхний 11 сард 16 хүүхэд үрчлэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. ҮРЧЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ, насны бүлгээр, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд	13	19	25	13	16
0-3 хүртэл	5	5	14	5	9
3-6	1	2	-	4	6
7-9	2	6	6	1	-
10 ба түүнээс дээш	5	6	5	3	1

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс




НИЙГМИЙН ДААТГАЛ

2025 оны эхний 12 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 26364.9 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ. Нийгмийн даатгалын сангаас 2025 оны эхний 12 сард 68530 даатгуулагч иргэнд 69429.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

ХҮСНЭГТ 6. НИЙГМИЙНДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2024		2025*	
	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая.төг)	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая.төг)
Нийт орлого	-	22 011.6	-	26 364.9
Тэтгэврийн даатгалын сан	-	18 453.8	-	22 065.9
Тэтгэмжийн даатгалын сан	-	1 918.5	-	2 351.6
ҮОМШӨ-ний даатгалын сан	-	1 283.9	-	1 167.4
Ажилгүйдлийн даатгалын сан	-	355.4	-	780.0
Нийт зардал	69 258	61 433.9	68 530	69 429.1
Тэтгэврийн даатгалын сан	62 539	52 996.9	63 574	59 776.3
Өндөр насны тэтгэвэр	45 459	38 053.6	46 471	43 321.4
Тахир дутуугийн тэтгэвэр	8 234	5 172.9	8 366	5 660.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	3 224	2 027.1	3 390	2 252.6
Цэргийн тэтгэвэр	5 622	7 743.3	5 347	8 541.4
ҮОМШӨ-ний даатгалын сан	4 291	4 212.4	3 451	3 998.6
Тахир дутуугийн тэтгэвэр	3 918	4 020.8	3 189	147.7
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	185	149.5	155	5.0
Сувилалын зардал	142	19.6	86	22.8
ҮОМШӨ ХЧТА ¹	46	22.5	22	4 174.1
Тэтгэмжийн даатгалын сан	1 232	2 450.3	846	3 116.7
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	498	205.6	348	223.1
Жирэмсний амралт	523	1 803.2	342	2 533.6
Оршуулга	211	441.5	180	360.0
Ажилгүйдлийн даатгалын сан	1 196	1 774.3	659	2 362.0
Ажилгүйдлийн тэтгэмж	1 196	1 774.3	659	2 362.0

ЗУРАГ 3. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА



Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо эхний 12 сард 63574 иргэнд олгосон тэтгэврийн хэмжээ 59776.3 сая төгрөгт хүрчээ.

Эх үүсвэр: Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан




ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 12 сард амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 хүнээр (1.2%), нас баралт 33 хүнээр (12.5%)-иар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 7. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025*
Амаржсан эхийн тоо, бүгд	846	782	670	662
Амьд төрсөн хүүхэд	858	790	671	666
Амьгүй төрсөн	7	2	10	2
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Нас баралт	257	258	265	232
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	10	15	4	11
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	25	31	39	66
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	168	185	176	111
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	63	42	50	55

ЗУРАГ 3. НАС БАРАЛТ



ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025*
Нийт халдварт өвчин	4 802	417	293	316
Хурц халдварт өвчин:	4 515	196	108	156
Хепатит В, С вирус	-	3	2	1
Менингит	-	-	-	1
Салхин цэцэг	11	83	67	29
Паротит	-	2	4	-
Дизентери	3	9	8	7
Ёлом	-	-	1	3
Бруцеллез	-	1	1	1
Бактерийн гаралтай хоолны хордлого	-	1	4	13
Сальмонеллөз	-	-	4	1
Гар, хөл, амны өвчин	5	25	15	5
Эритема B08.3	-	-	-	8
Хумхаа	-	1	-	-
Улаан эсэргэнэ	1	10	4	1
Улаан бурхан	-	-	-	75
Энтеровирус/ тодорхойгүй	1	-	-	-
Хумхаа	-	1	-	-
B34.1	-	-	-	6

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

Бусад халдварт өвчин		15	2	6
Ковид	4 494	61	-	-
Арьс өнгөний өвчин	256	186	163	134
Тэмбүү	107	97	83	70
Заг хүйтэн	71	44	47	48
Бэлгийн замын мөөгөнцөр	31	20	15	-
Трихомониаз	46	25	18	16
ХДХВ	-	-	16	-
Сүрьеэ	31	35	22	25

Дүүргийн хэмжээнд нийт халдварт өвчинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хүнээр (7.8%), хурц халдварт өвчин 46 (43.0%) тус тус өсөж, арьс өнгөний өвчлөл 29 (17.8%) буурч, сүрьеэ тухайн үетэй ижил байна.

ХҮСНЭГТ 9. ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Урьдчилан сэргийлэх тарилга	7 732	7 574	7569	7150	7487
Амбулаторын үзлэг	223 749	233 966	245 206	238 026	238716
Ор хоног	59 685	53 525	58 466	59 752	47258
Эмчийн тоо	84	84	93	94	96
Сувилагчийн тоо	100	100	108	111	118
Орны тоо	235	325	227	227	245

Эх үүсвэр: Налайх дүүргийн эрүүл мэндийн төв



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2025 оны эхний 12 сард нийтдээ 7 төрлийн 81 ажил, үйлчилгээг явуулж, 18565 хүнд үйлчилсэний 7812 том хүн, 10753 нь хүүхэд байна. Үйлчилгээний нийт орлого 31.7 сая төгрөг байна.

ХҮСНЭГТ 10. СОЁЛ, УРЛАГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, эхний 12 сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс						Номын сан (уншигчид)	ОНСТ үзэгчид
		Урлагийн тоглолт	Олон нийтийн ажил	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	81	15	24	10	15	3	9	1	1
Үйлчлүүлэгчийн тоо									
Нийт	18 565	2 518	6 595	1 898	5 249	359	525	629	792
Том хүн	7 812	1 957	3 875	974	329	187	3	236	243
Хүүхэд	10 753	561	2 720	924	4 920	172	522	393	549

Эх үүсвэр : Налайх дүүргийн Соёлын ордон



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2025 оны эхний 12 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 798.5 сая төгрөг болж, орлогын 43.0 хувийг орон сууц, 40.5 хувийг гэр хороолол, 16.5 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 105.8 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 11. ХОТ ТОХИЖИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025*	Үүнээс:
----------	------	------	------	-------	---------

					Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого сая / төг	331.3	484.6	773.7	798.5	343.0	323.1	132.4
Хог тээвэрлэлт мян / тн	61.4	78.3	111.9	105.8	33.5	45.1	27.2

Эх үүсвэр: Налайх дүүргийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

2025 оны эхний 12 сард дүүргийн хэмжээнд 533.5 мянган м³ ус борлуулснаас, 296.8 мянган м³ (55.6%) усыг хүн амд, 236.7 мян.м³ (44.4%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

ХҮСНЭГТ 12. ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025*
Шахсан ус мянган м³	861.0	624.0	673.4	1001.0
Борлуулсан ус мянган м³	489.0	380.0	476.6	533.5
Үүнээс: Хүн амд мянган м³	332.3	246.8	306.6	296.8
Аж ахуйн нэгж байгууллагад мянган м³	156.7	133.2	170.0	236.7
Татан зайлуулсан бохир мянган м³	581.3	347.0	378.4	438.3
Ус борлуулалтын орлого сая төгрөг	660.6	680.6	921.4	960.2
Сувагжуулалтын орлого сая төгрөг	442.0	286.5	513.5	752.7
Халаалтын орлого сая төгрөг	260.5	321.8	280.8	303.8


Эх үүсвэр: Налайх дүүргийн Чандмань Налайх ОНӨААТҮГазар



ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэгт 2025 оны эхний 12 сард 314 гэмт хэрэг бүртгэгдснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 (0.3%-иар буурсан байна.

ЗУРАГ 5. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧИД, насны байдлаар




ХҮСНЭГТ 13. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	279	329	597	315	314
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	11	9	90	5	-
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	4	1
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	4	11	16	19
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан	155	138	177	154	126

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		10	5	5	4	
Өмчлөх эрхийн гэмт хэрэг		54	119	238	117	97
Үүнээс	Хулгай	24	52	87	86	35
	Залилах	26	69	65	12	52
	Хөрөнгө завших	-	-	-	-	3
	Авто тээвэр хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	1	-	2	1	1
	Дээрэм	2	5	2	1	3
	Малын хулгай	2	1	1	1	1
	Халаасны хулгай	-	-	1	2	2
Бусад		31	37	78	12	26
Авто тээвэр		11	11	13	24	45
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		235	255	407	294	307
Ажилгүй		162	172	248	112	193
Албан хаагч		7	14	12	8	13
Оюутан, сурагч		11	21	25	23	9
Малчин		5	4	3	8	1
Төрийн бус байгууллагын ажилтан		5	3	8	6	3
ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч		45	41	104	133	85
Тэнэмэл		-	-	5	-	2
Сургуульд завсардсан хүүхэд		-	-	1	4	-
Хугацаат Цэргийн албан хаагч		-	-	1	-	1
Хоригдол		-	-	-	-	-
Эрүүлжүүлэгдсэн хүн		2 238	1 674	904	385	465

ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороодоор




Эх үүсвэр: Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс



ТӨСӨВ

2025 оны эхний 12 сард дүүргийн төсөвт 27427.0 сая төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.

ЗУРАГ 7. ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО, төрлөөр



Эх үүсвэр: Налайх дүүргийн Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс Тэмээний шир 20000 төгрөг (25.0%), Адууны дэл 1500 төгрөг (50.0%), Адууны сүүл 4000 төгрөг (0.7%) тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 14. ЗАРИМ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ, жил бүрийн эхний 12 сард

Түүхий эдийн нэр	2021	2022	2023	2024	2025*
	төгрөг				
Тэмээний шир ширхэг	10 000	10 000	30 000	80 000	60 000
Адууны шир ширхэг	8 000	10 000	17 000	9 000	-
Адууны дэл кг	7 000	7 000	5 000	3 000	1 500
Адууны сүүл кг	12 000	12 000	15 000	12 000	8 000
Үхрийн шир (дундаж үнэ) 1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	11 000	11 500	10 000	10 000	10 000
Хонины ноостой арьс ширхэг	500	500	0	0	-
Ямааны ноолууртай арьс	40 000	33 000	45 000	45 000	60 000

ХҮСНЭГТ 15. ШАТАХУУН ҮНЭ, литр, төгрөг, жил бүрийн 12 сард

ШТС	2024.XII. 24					2025.XII. 22				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	-	2590	3140	-	-	-	2 590	3 140	-
Петровис	3610	2370	2590	3140	-	3 610	2 370	2 590	3 140	-
Магнай трейд	3610	-	2590	3140	-	3 610	-	2 590	3 140	-
Сод монгол	3610	2315	2590	3140	-	3 610	2 315	2 590	3 140	-
Шунхлай	3610	2350	2590	3140	-	3 610	2 350	2 590	3 140	-
Юнигаз	-	-	-	-	1950	-	-	-	-	1 950
Дундаж үнэ	3610	2345	2590	3140	1950	3 610	2 345	2 590	3 140	1 950

ЗУРАГ 8. ШАТАХУУНЫ ДУНДАЖ ҮНЭ, литр төгрөг, 12 сард



Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн



АЖ ҮЙЛДВЭР

2025 оны эхний 12 сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 23.1 хувь, цахилгаан эрчим хүч 28.0 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт			
	Биет хэмжээгээр		Үнийн дүнгээр, сая/төг	
	2024	2025*	2024	2025*
Эрчим хүчний үйлдвэр				
Цахилгаан сая.квт.цаг	218.2	279.3	48 240.7	73 761.6
Дулаан мянган гкал	82.8	101.9	4 592.8	8 822.2
Олборлох үйлдвэр				
Шохой тонн	13.2	-	199.1	-
Элс мянган м³	35.3	44.3	572.5	464.2
Хайрга мянган м³	10.0	43.0	197.6	920.8
Дайрга мянган м³	1.3	-	11.6	-
Боловсруулах үйлдвэр				

Тоосго мян.ширхэг	3 889.2	4 486.2	908.7	1 868.1
Цемент мянган.тонн	20.2	27.3	4 608.3	7 177.7
Бетон зуурмаг м3	26.5	35.6	6 561.9	8 907.8
Аюултай хог хаягдал булах мянган тонн	0.8	1.0	1 072.7	1 466.4
Аюулгүй хог хаягдал зайлуулах мянган тонн	108.1	107.4	1 868.0	2 734.9
Оёдол /сурагчийн дүрэмт хувцас/ мянган ширхэг	14.9	17.4	946.0	911.8
Берзинтэн цүнх мянган ширхэг	-	4.1	-	206.2
Резинэн эдлэл сая.төг	4 285.7	13 745.5	4 285.7	13 745.5
Хүндрүүлэгч ширхэг	12 034.5	8 053.5	12 034.5	8 053.5
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл				
Талх тонн	5.9	26.7	25.5	109.7
Нарийн боов, жигнэмэг тонн	7.8	27.1	29.6	107.2
Цэвэр ус мян. литр	9 970.2	8 716.7	3 779.4	3 810.2

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн мэдээ



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 84 (10.4%) буурсан байна. Нийт суурин телефон цэгийн 372 (51.3%) нь айл өрх, 256 (35.3%) нь төсвийн байгууллагад, 97 (13.4%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

ХҮСНЭГТ 18. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Нийт орлого сая төгрөг	318.4	437.2	564.4	565.7	629.5
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний сая төгрөг	156.0	214.2	276.5	277.2	308.5
Телефон цэг тоо	808	940	849	809	725
Үүнээс: айл өрх тоо	506	545	454	436	372
Интернет үйлчилгээний цэг тоо	2	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал тоо	17	8	2	2	2
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид тоо	565	450	650	450	400
Интернетийн байнгын хэрэглэгчид тоо	600	799	550	512	416

Эх үүсвэр: Налайх дүүргийн шуудан, холбоо



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2025 оны эхний 12 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг 273 объектод хийснээс, 845 зөрчил илрүүлэн, 782 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 104, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 210, танилцуулга 7, гал түймэр унтраасан нотломж 113, гал түймэр гаргасан тухай акт 23, мэдэгдэл 54, хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 99 дуудлагаар ажиллаж 3125.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

ХҮСНЭГТ 19. ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГА, жил бүрийн эхний 12 сард

Үзүүлэлт	Хэм- жих нэгж	2021	2022	2023	2024	2025*
Бүгд	тоо	47	59	69	86	113
Өмчийн хэлбэрээр						
Төрийн өмч	тоо	-	12	4	1	
Хувийн өмч	тоо	46	32	59	54	94
Аж ахуйн нэгж	тоо	1	15	6	30	19
Хамтын болон гадаад улс	тоо	-	-	-	1	
Гал түймэрт өртөж шатсан						
Өвөл зуны сууц	тоо	5	16	22	38	58
Гэр	тоо	6	16	18	18	25
Хог, хогийн суваг	тоо	6	8	10	14	10
Машин техник	тоо	4	5	5	7	9
Барилга байгууламж	тоо	8	8	6	7	8
Малын хашаа саравч	тоо	6	5	8	1	3
Бусад						
Улсын онц чухал объект	тоо	12				-
Шалтгаан						
Цахилгааны	тоо	15	31	43	51	77
Гагнуур, паялник, бамбараас	тоо	-	-	-	3	-
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	12	7	7	-	19
Лаа, тамхи, шүдэнз	тоо	6	5	5	-	-
Хүүхдийн болгоомжгүй үйл ажиллагаанаас	тоо	2	-	-	-	-
Пийшин зуухны цонолт	тоо	5	11	11	19	9
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	2	5	2	7	3
Машин, техникийн яндангийн оч	тоо	2	5	4	7	-
Архидан согтуурснаас	тоо	2	-	-	1	-
Бусад	тоо	2	-	-	2	1
Шалтгаан тогтоогдоогүй	тоо	3	-	-	3	4
Аварсан эд хөрөнгө						
Өвөл зуны сууц	тоо	-	-	-	-	45
Гэр	тоо	9	12	18	7	-
Барилга байгууламж	тоо	-	-	5	10	40
Машин техник	тоо	1	17	17	6	-
Нийтийн орон сууц	тоо	0	-	-	1	-
Галын онц аюултай объект	тоо	-	-	-	1	-
Малын хашаа саравч	тоо	-	5	5	1	-
Эд хөрөнгө	Сая төг	3 122.0	2 975.6	3 895.0	13 380.7	3 125.0

Эх үүсвэр: Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс

ХҮСНЭГТ 20. ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭЛТ, жил бүрийн эхний 12 сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох, баталгаажуулах	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил, талбайг өөрчлөх	Газар эзэмших эрх сэргээх хугацаа сунгах	Газар эзэмших эрхээ цуцлуулах хүсэлт гаргасан
Иргэн, ААНБ-ын тоо	62	192	436	1576	45	20	354	146	-

2025 оны эхний эхний 12 сард дүүргийн Засаг даргын 23 удаагийн захирамжаар нийт 1030 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой захирамж гарсанаас 947 иргэн, 83 аж ахуйн нэгж байгууллагын асуудлыг шийдвэрлэсэн. Албаны даргын 74 удаагийн тушаалаар нийт 1704 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын захирамж гарсанаас 1609 иргэн, 95 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

Эх үүсвэр: Налайх дүүргийн Газар зохион байгуулалтын алба



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, дижитал сити, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2025 оны эхний 12 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 1838 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 1832 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, 6 нь хариу өгөх хугацаа болоогүй болон судлагдаж байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 99.0 хувьтай байна. Ирсэн өргөдөл, гомдол саналын 1492 (81.2%) нь бичгээр, 346 (18.8%) нь утсаар болон цахим системээр ирсэн байна.

Эх үүсвэр: Налайх дүүргийн ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк : <http://www.ubstat.mn/Report>
Налайх дүүргийн Статистикийн хэлтэс facebook page хуудас
Утас: 7023-3672